БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

# БАЯНХОНГОР СУМЫН 13 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**АУДИТЫН КОД: БНА-2021/180/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2021 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584, 99007576

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424, 99442140

Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Азбаяр

Утас: 99061429
Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/ ..... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9
3.Аудитын тайлан ..... 11
3.1. Ерөнхий зүйл ..... 11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..... 11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ..... 11
3.4. Материаллаг байдал ..... 11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ..... 13
3.7. Шилэн дансны мэдээлэл ..... 14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 14
3.9. Аудитын илрүүлэлт ..... 15
Залруулсан алдаа ..... 15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ..... 15
Аудитын зөвлөмж ..... 15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ..... 15
4. Менежментийн захидал ..... 16
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ..... 17

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021. 02. 25 № 2/177

танай ____________ -ны №____________ -т

БАЯНХОНГОР СУМЫН 13 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ц.ОЮУНЧИМЭГ ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 95.4 хувийн биелэлттэй гүйцэтгэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Аудитын гол асуудал

Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс их байгаа нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Захирал нягтлан бодогч нар нь амралтын цалин болон үр дүнгийн урамшуулал авахдаа 2709,1 мянган төгрөгийг давхардуулан авсан.
- Шунхлай трейдинг ХХК-руу 2020.12.14-нд 1000,0 мянган төгрөгийн шатахууны үнэ шилжүүлсэн боловч эд хариуцагчийн тайланд замын хуудас байхгүй.
- Хандив тусламжаар авсан 245,0 мянган төгрөгийн бараа материалыг орлого, зарлагад тусгагдаагүй, тооллого явуулхад агуулхад байхгүй, хүүхдүүдэд тараасан гэх тайлбар өгсөн боловч баримтаар нотлогдохгүй байна.
- "ДЭВЖИХ БОЛОР" ХХК-нд 12257,1 мянган төгрөг шилжүүлсэн боловч бараа материалыг хүлээн авах акт үйлдээгүй хүлээн авсан эсэх нь тодорхойгүй.

Дээрх алдаа зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн 13.4-т заасан "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Ээлжийн амралт олгох заавар”-ын 13 дахь хэсэгт заасан “Ажил олгогч нь ажилтныг ажлаас халагдахаас бусад тохиолдолд болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол биеэр эдлээгүй ээлжийн амралтын оронд мөнгөн олговор олгож болохгүй” гэсэн заалтуудтай нийцэхгүй санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **39,795,131.00** | **66,331,969.00** |
| **33** | **АВЛАГА** | 994,262.00 | 00.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 994,262.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 38,800,869.00 | 66,331,969.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 30,228,869.00 | 51,348,069.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 30,209,969.00 | 50,339,569.00 |
| 35130 | Эм боох материал | 18,900.00 | 1,008,500.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 8,572,000.00 | 14,983,900.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 237,300.00 | 187,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 238,100.00 | 3,103,600.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 77,000.00 | 5,152,100.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,478,600.00 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 6,541,000.00 | 6,541,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **483,347,888.13** | **460,655,725.77** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 483,347,888.13 | 460,655,725.77 |
| **392** | **Биет хөрөнгө** | 458,054,554.93 | 435,538,392.61 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 457,121,172.00 | 457,121,172.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -43,506,542.36 | -57,794,268.32 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 35,121,844.27 | 40,370,344.27 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -19,937,857.42 | -27,627,307.18 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 38,997,360.62 | 38,997,360.62 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -12,953,533.42 | -18,301,019.98 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,200,000.00 | 2,200,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -73,333.34 | -513,333.38 |
| 39217 | Ном | 1,085,444.58 | 1,085,444.58 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 25,293,333.20 | 25,117,333.16 |
| 39301 | Програм хангамж | 880,000.00 | 880,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -586,666.80 | -762,666.84 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 25,000,000.00 | 25,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **523,143,019.13** | **526,987,694.77** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **300,000.00** | **302,537.07** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 300,000.00 | 302,537.07 |
| **413** | **Өглөг** | 300,000.00 | 302,537.07 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 300,000.00 | 302,537.07 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **522,843,019.13** | **526,685,157.70** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 522,843,019.13 | 526,685,157.70 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 25,000,000.00 | 25,000,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 25,000,000.00 | 25,000,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 497,843,019.13 | 501,685,157.70 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 497,843,019.13 | 497,843,019.13 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 3,842,138.57 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **523,143,019.13** | **526,987,694.77** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **300,964,300.00** | **357,935,800.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,200,000.00** | **5,388,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,200,000.00 | 5,388,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,200,000.00 | 5,388,500.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 2,200,000.00 | 5,388,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **298,764,300.00** | **352,547,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 271,614,300.00 | 318,110,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 271,614,300.00 | 318,110,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 27,150,000.00 | 34,436,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 27,150,000.00 | 34,436,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **294,579,177.23** | **354,093,661.43** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **294,579,177.23** | **354,093,661.43** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 294,107,847.23 | 351,345,149.95 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 181,864,858.00 | 222,984,529.21 |
| 210101 | Үндсэн цалин | 156,284,458.00 | 204,657,946.21 |
| 210102 | Нэмэгдэл | 12,917,300.00 | 11,488,383.00 |
| 210104 | Урамшуулал | 12,663,100.00 | 6,838,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 21,702,538.00 | 28,704,458.38 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,117,038.00 | 19,612,601.07 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,487,600.00 | 2,338,205.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,333,200.00 | 1,951,445.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 503,000.00 | 678,505.31 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,261,700.00 | 4,123,702.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,995,612.00 | 29,336,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,507,596.00 | 2,338,812.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,595,473.00 | 24,229,274.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,892,543.00 | 2,768,314.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,109,300.00 | 5,256,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,392,300.00 | 33,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 220,000.00 | 1,600,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,021,089.00 | 1,389,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 56,000.00 | 18,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 492,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,239,911.00 | 1,722,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 38,832,115.00 | 31,245,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 73,800.00 | 1,203,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 38,297,315.00 | 30,042,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 461,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 564,600.00 | 1,198,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 564,600.00 | 1,198,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 105,000.00 | 105,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 105,000.00 | 105,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 644,900.00 | 2,513,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 394,900.00 | 2,213,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 300,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22,288,924.23 | 30,001,062.36 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 409,500.00 | 2,060,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 21,879,424.23 | 27,940,662.36 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 471,330.00 | 2,748,511.48 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 112,200.00 | 113,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 112,200.00 | 113,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 354,388.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 354,388.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,742.00 | 2,635,511.48 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,742.00 | 2,635,511.48 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **6,385,122.77** | **3,842,138.57** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **6,385,122.77** | **3,842,138.57** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **298,764,300.00** | **352,547,300.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **298,764,300.00** | **352,547,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 271,614,300.00 | 318,110,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 271,614,300.00 | 318,110,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 27,150,000.00 | 34,436,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 27,150,000.00 | 34,436,500.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **279,487,300.00** | **352,547,300.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **279,487,300.00** | **352,547,300.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **279,015,970.00** | **349,798,788.52** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 181,565,358.00 | 222,963,846.52 |
| 210101 | Үндсэн цалин | 155,984,958.00 | 182,373,752.58 |
| 210102 | Нэмэгдэл | 12,917,300.00 | 24,266,783.94 |
| 210104 | Урамшуулал | 12,663,100.00 | 13,672,094.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 2,651,216.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 22,696,300.00 | 27,728,342.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,175,500.00 | 19,716,642.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,630,200.00 | 2,003,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,304,200.00 | 1,602,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 325,900.00 | 400,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,260,500.00 | 4,005,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,995,612.00 | 29,336,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,507,596.00 | 2,338,812.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,595,473.00 | 24,229,274.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,892,543.00 | 2,768,314.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,953,900.00 | 8,349,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 290,200.00 | 102,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 220,000.00 | 1,600,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,021,089.00 | 1,389,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 56,000.00 | 56,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 876,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,186,611.00 | 4,325,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 40,588,300.00 | 43,282,500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 52,400.00 | 2,052,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | 39,032,900.00 | 28,563,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,503,000.00 | 12,666,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,482,000.00 | 7,273,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,482,000.00 | 6,273,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 105,000.00 | 105,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 105,000.00 | 105,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 644,900.00 | 856,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 394,900.00 | 556,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 300,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,984,600.00 | 9,903,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 8,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,984,600.00 | 1,903,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **471,330.00** | **2,748,511.48** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 112,200.00 | 113,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 112,200.00 | 113,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 354,388.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 354,388.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,742.00 | 2,635,511.48 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,742.00 | 2,635,511.48 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **19,277,000.00** | **00.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-19,277,000.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **19,277,000.00** | **00.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **19,277,000.00** | **00.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **19,277,000.00** | 00.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 19,277,000.00 | 00.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-19,277,000.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| D01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **25,000,000.00** | **00.00** | **497,843,019.13** | **00.00** | 522,843,019.13 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **25,000,000.00** | **00.00** | **497,843,019.13** | **00.00** | 522,843,019.13 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 3,842,138.57 | 00.00 | 3,842,138.57 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **25,000,000.00** | **00.00** | **501,685,157.70** | **00.00** | 526,685,157.70 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | | **Зөрүү** | **Хувь** |
|---|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 352,547,300.00 | 349,911,788.52 | 2,635,511.48 | 99.3 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 352,547,300.00 | 349,911,788.52 | 2,635,511.48 | 99.3 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 352,434,300.00 | 349,798,788.52 | 2,635,511.48 | 99.3 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 222,991,900.00 | 222,963,846.52 | 28,053.48 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 186,716,000.00 | 182,373,752.58 | 4,342,247.42 | 97.7 |
| 210102 | Нэмэгдэл | 20,599,700.00 | 24,266,783.94 | -3,667,083.94 | 117.8 |
| 210104 | Урамшуулал | 13,676,200.00 | 13,672,094.00 | 4,106.00 | 100.0 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2,000,000.00 | 2,651,216.00 | -651,216.00 | 132.6 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 28,814,400.00 | 27,728,342.00 | 1,086,058.00 | 96.2 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,802,700.00 | 19,716,642.00 | 1,086,058.00 | 94.8 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,003,000.00 | 2,003,000.00 | 0.00 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,602,300.00 | 1,602,300.00 | 0.00 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 400,600.00 | 400,600.00 | 0.00 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,005,800.00 | 4,005,800.00 | 0.00 | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 29,336,400.00 | 29,336,400.00 | 0.00 | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,066,100.00 | 2,338,812.00 | -272,712.00 | 113.2 |
| 210302 | Түлш, халаалт | 24,498,900.00 | 24,229,274.00 | 269,626.00 | 98.9 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,771,400.00 | 2,768,314.00 | 3,086.00 | 99.9 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,349,100.00 | 8,349,100.00 | 0.00 | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 102,000.00 | 102,000.00 | 0.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,600,000.00 | 1,600,000.00 | 0.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,389,600.00 | 1,389,600.00 | 0.00 | 100.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 56,500.00 | 56,500.00 | 0.00 | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 876,000.00 | 876,000.00 | 0.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,325,000.00 | 4,325,000.00 | 0.00 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 43,282,900.00 | 43,282,500.00 | 400.00 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,052,700.00 | 2,052,700.00 | 0.00 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 28,563,800.00 | 28,563,400.00 | 400.00 | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 12,666,400.00 | 12,666,400.00 | 0.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,794,300.00 | 7,273,300.00 | 1,521,000.00 | 82.7 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,521,000.00 | 1,000,000.00 | 1,521,000.00 | 39.7 |
| 210604 | Урсгал засвар | 6,273,300.00 | 6,273,300.00 | 0.00 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 105,700.00 | 105,700.00 | 0.00 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 105,700.00 | 105,700.00 | 0.00 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 856,000.00 | 856,000.00 | 0.00 | 100.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 556,000.00 | 556,000.00 | 0.00 | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 300,000.00 | 0.00 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9903600.00 | 9903600.00 | 0.00 | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,000,000.00 | 8,000,000.00 | 0.00 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,903,600.00 | 1,903,600.00 | 0.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 113000.00 | 113000.00 | 0.00 | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 113,000.00 | 113,000.00 | 0.00 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 113,000.00 | 113,000.00 | 0.00 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 352,547,300.00 | 349,911,788.52 | 2,635,511.48 | 99.3 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 352,547,300.00 | 349,911,788.52 | 2,635,511.48 | 99.3 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 318,110,800.00 | 315,475,288.52 | 2,635,511.48 | 99.2 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 34,436,500.00 | 34,436,500.00 | 0.00 | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 34,436,500.00 | 34,436,500.00 | 0.00 | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 19.00 | 19.00 | 0.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 13.00 | 13.00 | 0.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 05.00 | 05.00 | 0.00 | 100.0 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч Ц.Оюунчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 23-наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтээ Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 18-ны өдөр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг Сургуулийн өмнөх боловсрол олгох гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн 2020 оны төсөвт дотоод хяналт болон шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийгдээгүй байна.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн төвшнийг “Их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын төвшнийг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлын 354093,7 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 7081,9

мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын төвшнийг багасгах шаардлага гараагүй.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 526987,7 мянган төгрөг болж өмнөх оноос 3844,7 мянган төгрөгөөр буюу 0,7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 39,795.1 | 66,332.0 | 26,536.8 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 994.3 | - | (994.3) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 38,800.9 | 66,332.0 | 27,531.1 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 483,347.9 | 460,655.7 | (22,692.2) |
| Үндсэн хөрөнгө | 560,405.8 | 565,654.3 | 5,248.5 |
| Хуримтлагдсан элэгдэл | (77,057.9) | (104,998.6) | (27,940.7) |
| **Нийт хөрөнгө** | 523,143.0 | 526,987.7 | 3,844.7 |
| Өр төлбөр | 300.0 | 302.5 | 2.5 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 522,843.0 | 526,685.2 | 3,842.1 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 523,143.0 | 526,987.7 | 3,844.7 |

Тухайн байгууллага нь өмнөх онд 994,3 мянган төгрөг байсан бол тайлант онд тухайн авлагыг барагдуулсан байна. Өмнөх оны эхний үлдэгдлээр илэрхийлэгдсэн авлага ажиллагсадтай холбоотой авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 66332,0 мянган төгрөг болж өмнөх оноос 27531,1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд Тусгай зориулалтын материал 30209,9 мянган төгрөгөөс 50339,6 мянга, Аж ахуйн материал 238,1 мянган төгрөгөөс 3103,6 мянга, Барилгын засварын материал 77,0 төгрөгөөс 5152,1 мянган төгрөг болж тус тус өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны өмнөх оны үлдэгдэл 560405,8 мянган төгрөг байсан бол тайлант оны эцэст 565654,3 мянган төгрөг болж 5248,5 мянган төгрөгөөр нэмэгдсэн тайлант онд тоног төхөөрөмжийн дансанд 3 ширхэг зөөврийн компьютер авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны өмнөх оны үлдэгдэл 522843,0 мянган төгрөг байсан бол тайлант онд 526685,2 мянган төгрөг болсон нь тайлант оны үр дүн байна.

Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх онд 300964,3 мянган төгрөг байсан бол тайлант онд 357935,8 мянган төгрөг болж 56971,5 мянган төгрөгөөр буюу 18,9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь тусгай шилжүүлгийн санхүүжилт нь 271614,3 мянган төгрөгөөс 318110,8 мянган төгрөг болж 46496,5 мянган төгрөгөөр, орон нутгаас санхүүжих тогтмол зардал 34436,5 мянган төгрөг

болж өмнөх оноос 7286,5 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй авсан орлого 5388,5 мянган төгрөг болж болж өмнөх оноос 3188,5 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт зардал өмнөх онд 294579,2 мянган төгрөг байсан бол тайлант онд 354093,7 мянган төгрөг болж 59514,5 мянган төгрөгөөр буюу 20,2 хувиар өссөн байна. Энэ нь тайлант хугацаанд цалингийн зардал өмнөх оноос 41119,7 мянга, ажил олгогчоос төлөх ЭМНДШ 13357,0 мянга, Тогтмол зардал 5340,8 мянга, хангамж материалын зардал 1147,2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 1868,3 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 7712,1 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 2277,2 мянган төгрөгөөр тус тус өссөн бол нормативт зардал 7587,0 мянган төгрөгөөр буусан нь материаллаг дүнг эзэлж байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд үндсэн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 293421.0 мянган төгрөгөөр төсөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 51796,0 мянган төгрөгөөр нэмж 345217,0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүргүүлсэн саналаас гол нэмэгдэн зардал нь ЭМНДШ-д 8642,5 мянга, түлш халаалтын зардалд 11606,5 мянга хүүхдийн хоолны зардалд 26433,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталжээ.

Харин төсвийн тодотгол, зохицуулалтаар нийт 7330,3 мянган төгрөг нэмсэн бөгөөд үүнд цалин хөлсийг 20029,1 мянган төгрөгөөр нэмсэн бол тогтмол зардлыг 5800,1 мянган төгрөгөөр, бууруулсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 352547,3 мянган төгрөгийн төсөв батлсныг тусгай шилжүүлгээр 318110,8 мянга, орон нутгийн санхүүгийн дэмжлэгээр 34436,5 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс санхүүжилт бүрэн авч урсгал үйл ажиллагаанд 349911,8 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 2635,5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 349911,8 мянган төгрөг буюу 99,3 хувьтай байгаа нь ажил олгогчоос төлөх ЭМНДШ 1086,1 мянга, эд хогшил худалдан авах зардал 1521,0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| НИЙТ | 352,547,300.00 | 349,911,788.52 | 2,635,511.48 | **99.25** |
| **ХӨТӨЛБӨР 71801-Сургуулийн өмнөх боловсрол** | 352,547,300.00 | 349,911,788.52 | 2,635,511.48 | **99.25** |
| **АРГА ХЭМЖЭЭ 80109- Тогтмол зардал** | **34,436,500.00** | **34,436,500.00** | **-** | **100.00** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Бусад урсгал шилжүүлэг** | | **34,436,500.00** | **34,436,500.00** | - | **100.00** |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 29,336,400.00 | 29,336,400.00 | - | **100.00** |
| Урсгал засвар | | 5,100,100.00 | 5,100,100.00 | - | **100.00** |
| **АРГА ХЭМЖЭЭ 80802 -Ажил олгогчоос олгох тэтгэмж** | | **113,000.00** | **113,000.00** | - | **100.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шаг урамшуулал | 113,000.00 | 113,000.00 | - | **100.00** |
| **АРГА ХЭМЖЭЭ 81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол** | | **28,563,800.00** | **28,563,400.00** | **400.00** | **100.00** |
| Хоол, хүнс | | 28,563,800.00 | 28,563,400.00 | 400.00 | **100.00** |
| **АРГА ХЭМЖЭЭ 81834-Боловсролын стандарт сургалтын** | | **269,614,500.00** | **268,504,494.52** | **1,110,005.48** | **99.59** |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | | 209,315,700.00 | 209,291,752.52 | 23,947.48 | **99.99** |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 26,968,100.00 | 25,882,042.00 | 1,086,058.00 | **95.97** |
| Хангамж, бараа материалын зардал | | 5,573,100.00 | 5,573,100.00 | - | **100.00** |
| Нормативт зардал | | 14,719,100.00 | 14,719,100.00 | - | **100.00** |
| Эд хогшил, урсгал засварын зардал | | 2,173,200.00 | 2,173,200.00 | - | **100.00** |
| Томилолт, зочны зардал | | 105,700.00 | 105,700.00 | - | **100.00** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 856,000.00 | 856,000.00 | - | **100.00** |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага | | 9,903,600.00 | 9,903,600.00 | - | **100.00** |
| **АРГА ХЭМЖЭЭ 81835-Сургалтын үйл ажиллагаа** | | **19,819,500.00** | **18,294,394.00** | **1,525,106.00** | **92.31** |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | | 13,676,200.00 | 13,672,094.00 | 4,106.00 | **99.97** |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 1,846,300.00 | 1,846,300.00 | - | **100.00** |
| Хангамж, бараа материалын зардал | | 2,776,000.00 | 2,776,000.00 | - | **100.00** |
| Багаж хэрэгсэл | | 1,521,000.00 | | 1,521,000.00 | **0.00** |

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны сайтад 151 мэдээ мэдээлэхээс 148 мэдээллийг байршуулсан бөгөөд үүнээс 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бол 3 мэдээллийг байршуулаагүй байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд байршуулсан | Хугацаа хоцроож байршуулсан | Байршуулаагүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 6 | 2 | 3 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | 0 |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | 0 | 0 |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 35 | 1 | 0 |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 89 | 7 | 0 |
| 6 | Нийт | 27 | 151 | 138 | 10 | 3 |

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар 300,0 мянган төгрөгийн залруулга хийсэн байна .

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15966,2 мянган төгрөгийн 3 төрлийн зөрчил илэрснээс 2709,1 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1000,0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өгч 12257,1 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

**Залруулсан алдаа**

Аудитаар залруулга хийгдээгүй.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 2709,1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Захирал нягтлан бодогч нар нь амралтын цалин болон үр дүнгийн урамшуулал авахдаа 2709,1 мянган төгрөгийг давхардуулан авсан.нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Ээлжийн амралт олгох заавар”-ын 13 дахь хэсэгт заасан “Ажил олгогч нь ажилтныг ажлаас халагдахаас бусад тохиолдолд болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол биеэр эдлээгүй ээлжийн амралтын оронд мөнгөн олговор олгож болохгүй.”

**<u>Шийдвэрлэсэн нь:</u>**

Холбогдох албан тушаалтнаар 2709,1 мянган төгрөгийг төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. “Шунхлай трейдинг” ХХК-руу 2020.12.14-нд 1000,0 мянган төгрөгийн шатахууны үнэ шилжүүлсэн боловч эд хариуцагчийн тайланд замын хуудас байхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 13.4-т заасан "*Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна*" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**<u>Шийдвэрлэсэн нь:</u>**

Зарцуулалтын тайлангүй 1000,0 төгрөгийн шатахуунд төлбөрийн акт тогтоох

3. Хандив тусламжаар авсан 245,0 мянган төгрөгийн бараа материалыг орлого, зарлагад тусгагдаагүй, тооллого явуулхад агуулхад байхгүй, хүүхдүүдэд тараасан гэх тайлбар өгсөн боловч баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-т заасан “*Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**<u>Шийдвэрлэсэн нь:</u>**

Хандиваар ирсэн 245,0 мянган төгрөгийн бараа материалын төлбөрийг холбогдох албан тушаалтнуудаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 12257,1 мянган төгрөгийг 1 төрлийн зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

## 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Аудитаар ажичдад үр дүнгийн урамшуулал болон ур чадварын нэмэгдэл бодохдоо ажилчдад илүү тооцдог, шийдвэргүй зарцуулдаг, ажилчдаас бэлнээр буцаан авч болзошгүй эрсдэлтэй асуудал ажиглагдаж байгаа тул завсаоынг аудитаар энэ асуудлыг тусгайлан авч үзэх шаардлагатай байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**1. ТӨСӨВ,ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ**

1.1. Илрүүлэлт:
"ДЭВЖИХБОЛОР" ХХК-нд 2020.12.14 өдөр Норм зөөлөн эдлэлийн зардлаас 1431,0 мянга, Бараа үйлчилгээний зардлаас 6726,0 мянга, Засварын зардлаас 4100,1 мянга, нийт 12257,1 мянган төгрөг шилжүүлсэн боловч бараа материалыг хүлээн авах акт үйлдээгүй хүлээн авсан эсэх нь тодорхой бус байна.

1.2. Эрсдэл:
Төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах, хөрөнгө шамшигдах

1.3. Өгсөн зөвлөмж: Цаашид бэлтгэн нийлүүлэгчдээс хөрөнгө хүлээн авахдаа дотоод хяналтын нэгжийг ажиллуулж, чанар байдалд үзлэг хийн хөрөнгө хүлээн авсан актаар баталгаажуулж байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:
Хүлээн зөвшөөрсөн

**2. ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ**

2.1. Илрүүлэлт:
2020 оны 09 дүгээр сараас эхлэн эмчийн орон тоонд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож МХГ-ын албан хаагчыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулж байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 31-р зүйлд заасан хориглох зүйл, 31.1.3- д заасан “хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу шууд хяналт тавих албан хаагчтай хамаарал бүхий этгээд нь тухайн ажлын албаны нэгжид хамт ажиллахаар бол” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:
Төрийн албаны хууль зөрчигдөх

2.3. Өгсөн зөвлөмж: Цаашид МХГ-ын хяналтын байцаагчийн үүрэг гүйцэтгэж буй албан хаачтай гэрээ байгуулдаг байдлыг зогсоож, Төрийн албаны тухай хуулийг мөрдөж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:
Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:
АХЛАХ АУДИТОР: Б.АЗБАЯР 2021.02.25
АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЭНЯМ 2021.02.25
ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ 2021.02.25

## 5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|---|---|---|---|
| Огноо: 2020 он | Аудитын нэр: | ***Баянхонгор сум 13-р цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | Аудитын код: БНА-2021/180/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | ***Баянхонгор сумын 13-р цэцэрлэг*** | **Мянган төгрөг** |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Захирал нягтлан бодогч нар нь амралтын цалин болон үр дүнгийн урамшуулал авахдаа 2709,1 мянган төгрөгийг давхардуулан авсан. | 2709,1 | Төлбөрийн акт тогтоох. | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Ц.Оюунчимэг, Х.Одончимэг |
| 2 | Шунхлай трейдинг ХХК-руу 2020.12.14-нд 1000,0 мянган төгрөгийн шатахууны үнэ шилжүүлсэн боловч эд хариуцагчийн тайланд замын хуудас байхгүй байна. | 1000,0 | Төлбөрийн акт тогтоох | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Ц.Оюунчимэг, Х.Одончимэг |
| 3 | Хандив тусламжаар авсан 245,0 мянган төгрөгийн бараа материалыг орлого, зарлагад тусгагдаагүй, тооллого явуулхад агуулхад байхгүй, хүүхдүүдэд тараасан гэх тайлбар өгсөн боловч баримтаар нотлогдохгүй байна. | 245,0 | Төлбөрийн акт тогтоох | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Ц.Оюунчимэг, Х.Одончимэг |
| 4 | "ДЭВЖИХ БОЛОР" ХХК-нд 12257,1 мянган төгрөг шилжүүлсэн боловч бараа материалыг хүлээн авах акт үйлдээгүй хүлээн авсан эсэх нь тодорхойгүй. | 12257,1 | Зөвлөмж өгөх | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Ц.Оюунчимэг, Х.Одончимэг |
| 5 | 2020 оны 09 дүгээр сараас эхлэн эмчийн орон тоонд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож МХГ-ын албан хаагчыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулсан. | 1680,0 | Зөвлөмж өгөх | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | Ц.Оюунчимэг, Х.Одончимэг |
| **ДҮН** | | **17891,2** | | | |

- oOo -